



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 9/126

Мандалговь

Тооллогын комисс томилох тухай

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.5, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралт, Батлан хамгаалахын сайдын 2019 оны н/19 дүгээр тушаалаар батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 2.1.5 заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Цэргийн штабын 2022 оны эхний хагас жилийн дайчилгааны нууцын тооллого явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Ш.Гансүх (Цэргийн штабын дарга, дэд хурандаа)

Гишүүдэд: Ц.Баттулга (Цэргийн штабын ОНХ, сургалтын офицер дэд хурандаа)

Н.Сүхбаатар (СТСХ-ийн төсвийн ахлах мэргэжилтэн, Улсын дайчилгааны мэргэжилтэн)

2. Цэргийн штабын архив, албан хэрэг хөтлөлт, дайчилгааны нууцын баримт бичиг болон бусад нууц тээгчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд 2022 оны 06 дугаар сарын 02-ноос 04-ний хооронд нэг бүрчлэн тооллого хийж, цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг тусгаж акт үйлдэн холбогдох байгууллагад нь хүргүүлэхийг комиссын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
И. Мандалговь Л.ДОРЖБАТ

4822150292